



ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Боловсрол
судлалын сургууль
Хөтөлбөрийн нэр: Нийгмийн ажил
Индекс: 092301 магистр

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Нямдорж	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ажлын хөтөлбөрийн ахлах багш, доктор (Ph.D)
Гишүүд: Я.Отгонбаяр	Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)
Д.Мөнхчулуун	Нийслэлийн Аддиктологи, зан үйл, сэтгэл заслын төвийн Нийгмийн эрүүл мэнд, Сургалт, Эрдэм шинжилгээ хариуцсан орлогч дарга, доктор (Ph.D)

Улаанбаатар хот
2023 он

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр	Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Боловсрол судлалын сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр	Нийгмийн ажил	
Индекс	092301 магистр	
Шинжээчид	Ахлагч: Н.Нямдорж Гишүүд: Я.Отгонбаяр Д.Мөнхчулуун	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч П.Оргилмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2023.05.26	Шинжээчийн багтай гэрээ байгуулах
	2023.05.26	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах
	2023.06.02	Өөрийн үнэлгээний тайланг уншиж судлан дүгнэлт хийх, тодруулах асуудал бүхий урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид илгээх
	2023.06.06-07	Шинжээчийн баг сургууль дээр ажиллах
	2023.06.16	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт, тайланг илгээх.
	2023.06.16	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2022.06.19	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.06.20	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн нэр: “Нийгмийн ажил”

Индекс: 092301 магистр

Нийгмийн ажил, арга зүйн тэнхим нь 1997 онд Их Британийн Засгийн газрын түншлэлийн хөтөлбөрийн санхүүгийн шууд дэмжлэг, тусламжаар Улсын Багшийн Их Сургуулийн Сурган хүмүүжүүлэх ухаан, Сэтгэл Судлалын тэнхимийн дэргэд Нийгмийн ажлын сургалт, судалга арга зүйн төв нэртэйгээр анх байгуулагдсан. 1999 онд Нийгмийн ажлын тэнхим, Будапештын Соросрын Сангийн Дээд Боловсролыг Дэмжих Хөтөлбөрийн Академик хөтөлбөрийн түншлэгч тэнхим 2006-2008 онд, 2014 оноос Нийгмийн ажил арга зүйн тэнхим, 2016 онд Арктикийн бүсийн орны их сургуулиудын холбооны гишүүн болон өргөжсөн байна.

Нийгмийн ажил арга зүйн тэнхим 2001 оноос эхлэн Нийгмийн ажлын магистр бэлтгэж эхэлснээс хойш өнөөг хүртэл нийгмийн ажлын магистр зэрэгтэй 200 мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэсэн байна.

Хөтөлбөрийн зорилго

Нийгмийн сайн сайхан байдлыг бүрдүүлэх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бүс нутаг, олон улс, үндэсний түвшинд нөлөөлөх нийгмийн төлөвлөлт өөрчлөлт хийх, бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, шинжлэн судлах, нийгмийн ажлын шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах, нийгмийн ажлын салбаруудад холбогдох чиг үүрэг гүйцэтгэх мэдлэг, чадвар, хандлага бүхий судлаач мэргэжилтэн бэлтгэхэд нийгмийн ажлыг магистрын хөтөлбөрийн зорилго оршиж байна.

Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

- Нотолгоонд суурилсан, онол практикт суурилсан үйлчилгээ үзүүлэх
- Ахисан түвшинд суралцах хэрэгцээ шаардлага
- Нийгмийн болон Нийгмийн ажлын эрх зүйн орчин сүүлийн 10 жилийн хугацаанд ихээхэн өөрчлөлт гарсантай холбоотойгоор нийгмийн ажлын менежментийн хувьд мэргэжилтэн бэлтгэх шаардлага

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна

1.1 Хөтөлбөрийн баримт бичиг

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн дэд хороо болон ерөнхий хорооны дүрэм журмууд
- Хөтөлбөр боловсруулалтын үеийн баримт бичгүүд, хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд

- Хөтөлбөрийн агуулга болон хичээлийн хөтөлбөрүүдийг боловсруулахдаа гадаадын болон дотоодын ижил хөтөлбөрүүдтэй харьцуулан шинжилсэн шинжилгээний тайлан
- Магистр оюутанд олгох тэтгэлгийн журам
- Магистрант оюутны гарын авлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС нь “Нийгмийн ажил” магистрын хөтөлбөрөө БШУ-ны сайдын 2014 оны А/370 тушаалын нийтлэг шаардлагын дагуу боловсруулж, сургуулийнхаа хөтөлбөрийн дэд хороо болон ерөнхий хороогоор хэлэлцүүлэн зохих журмын дагуу боловсруулсан байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн/боловсрол/ болон судлаач магистрын тухай сургалтын хөтөлбөртэй тусгаж өгөх хэрэгтэй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрт оролцогч талуудын эрэлт хэрэгцээг нарийвчлан тодорхойлох;
- Хөтөлбөрийн төгсөгч- мэргэжилтний гол онцлог давуу талыг тодорхойлох;
- Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын уялдаа холбоог тодорхой харуулах, мэргэжлийн ахисан түвшний судалгааг хэрхэн хөгжүүлэх, онол ба практикийг хэрхэн зохистой хослуулах талаар бодлого төлөвлөгөө боловсруулах;

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн 2024 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний баримт бичиг
- Магистрын сургалтын журам
- Нийгмийн ажил-магистрын хөтөлбөрийн баримт бичиг
- Хөтөлбөр боловсруулалтын үеийн баримт бичгүүд, хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд
- Нийгмийн ажил хөтөлбөрөөр төгсөгчдийг тандах судалгаа
- Хөтөлбөрийн дэд хороо болон ерөнхий хорооны дүрэм журмууд
- Хөтөлбөр боловсруулалтын үеийн баримт бичгүүд, хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС нь 2001-2002 оны хичээлийн жилээс магистрын сургалтыг эрхэлсэн туршлагатай.
- Хөтөлбөрийн зорилгыг өнөөгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тодорхойлсон байна.

- Суралцахуйн зорилтот үр дүнг SLO-г тодорхойлоход PEO, PLO, Course Curriculum, POA -д шинжилгээ хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг боловсруулах
- Нийгмийн ажил хөтөлбөрөөр төгсөгчдийг тандах судалгаа

Зөвлөмж:

- Мэргэжлийн тэнхимээс элсэлттэй холбогдуулан баримтлах бодлого чиглэлийг тодорхой болгох;
- Элсэлттэй уялдуулан хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээг тогтмол хийдэг байх;
- Суралцагчийн суралцах ачааллын нарийвчлсан шинжилгээг хийж, үр дүнг нь хөтөлбөрийн хэрэгжилтэд тусгадаг байх;
- Хичээлийн хөтөлбөрүүдэд бие даан гүйцэтгэх ажлын удирдамж, арга зүй болон суралцахуйн үр дүнтэй хэрхэн холбогдож байгааг тодорхой тусгах;
- Хөтөлбөр хэрэгжүүлэх тэнхмийн судалгааны тэргүүлэх чиглэл, ололт амжилт, туршлага, үр дүн, дүгнэлтүүдээс тусгах;

1.3 Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн Магистр, докторын сургалтын журам
- БШУ-ны сайдын 2014 оны 09 сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаал, хоёрдугаар хавсралт
- Нийгмийн ажил-магистрын хөтөлбөрийн баримт бичиг
- Сүүлийн 3-5 жилийн сургалтын төлөвлөгөө
- Нийгмийн ажил-магистрын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн хөтөлбөрүүд
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба Хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хувь хүний ур чадвар, хандлага хоорондын хамаарлын матриц
- Хөтөлбөрийн дэд хороо болон ерөнхий хорооны дүрэм журмууд
- Хөтөлбөр боловсруулалтын үеийн баримт бичгүүд, хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн ба суралцахуйн үр дүнгийн хамаарлыг тусгасан байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг хувь хүний ба мэргэжилтэний хувьд мэдлэг, чадвар, хандлага гэсэн 3 үндсэн бүлгийн дагуу томъёолсон ба мэдлэгийг 12, чадварыг 12, хандлагыг 6 үндсэн категорт хувааж, дээрх мэдлэг, чадвар, хандлага нь сургалтын төлөвлөгөөний хичээлүүдтэй хэрхэн уялдаж байгаа матрицыг харуулсан байна.
- Хөтөлбөрийн агуулгыг хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн тодорхойлсон байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд нь суралцахуйн зорилтот үр дүнд

хүрэхэд чиглэн харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжиж байгааг сүүлийн 5 жилээр үнэлж, баталгаажуулах. Үүнд:

- Онол, практикийн оновчтой хослол
- Логик дэс дараалал
- Давхардал
- Сонгон суралцах боломж
- Суралцах хэлбэр, ачаалал гэх мэт

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн агуулгыг боловсруулахад оролцогч талуудын оролцоог хэрхэн хангаж буй байдлыг тусгаагүй байна. /Хөтөлбөрөөр төгсөгч, ажил олгогч нарын/

1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн Магистр, докторын сургалтын журам
- Нийгмийн ажил-магистрын хөтөлбөрийн баримт бичиг
- Нийгмийн ажил-магистрын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн хөтөлбөрүүд
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба Хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хувь хүний ур чадвар, хандлага хоорондын хамаарлын матриц
- Хөтөлбөр боловсруулалтын үеийн баримт бичгүүд, хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Анхаарах асуудал:

- Сургалтын үйл явцыг хосломол буюу тэнхим болон цахим хэлбэрээр явуулах хэрэгцээг тодорхойлох
- Сургалтын төлөвлөгөөн дэх суралцагчийн хичээл нэг бүрийн бие даан гүйцэтгэх цагийн болон сэдвийн задаргааг тусгах;
- Хөтөлбөрийн зарим хичээлүүдийн шинэчлэлд хичээлийн тодорхойлолт, үндсэн сурах бичгийн болон нэмэлт унших материалын сүүлийн 5-н жилд хэвлэгдсэн байдал дутууг бичих

Зөвлөмж:

- Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын уялдаа холбоог тодорхой харуулах, мэргэжлийн ахисан түвшний судалгааг хэрхэн хөгжүүлэх, онол ба практикийг хэрхэн зохистой хослуулах талаар бодлого төлөвлөгөө боловсруулах;

1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн зөвлөлөөс гаргасан тусгай шаардлага бүхий баримт бичиг
- БШУЯ-ны эрэлттэй мэргэжлийн жагсаалт
- Батлагдсан хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- МУБИС-ийн сургалтын журам
- МУБИС-ийн хөтөлбөрийн хорооны дүрэм журмууд
- Нийгмийн ажлын магистрын хөтөлбөртэй холбоотой судалгаанууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол улсад Нийгмийн ажлын анхдагч мэргэжилтэн бэлтгэсэн их сургуулийн нэг бөгөөд манлайлагч сургууль, тэнхим байх явдлаа 2022-2024 онд тэнхим хөгжүүлэх төлөвлөгөөндөө тодорхойлсон байна.

Анхаарах асуудал:

- Үндэсний болон олон улсын сайн туршлагыг өөрийн орны онцлогт байдлаар нутагшуулах талд анхаарах;

Зөвлөмж:

- Гадаадын болон дотоодын их сургуулиудын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан судалгаагаа илүү дэлгэрэнгүй тайландаа тусгах,

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOFEL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн Элсэлтийн журам. 2015.09.09 А/172
- МУБИС-ийн оюутанд тэтгэлэг олгох журам. 2021.05.12. А/80
- www.burtgel.msue.mn
- Магистр, докторын элсэлтэд зориулсан постер-2022 он.
- Нийгмийн сүлжээнд хөтөлбөрөөр элсэгч магистрантуудын пейж хуудас. ФБ МУБИС БоСС НА, НАХАЗ
- Суралцагчийн ачаалалыг тодорхойлсон баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2,7 голчоос дээш үнэлгээтэй суралцагч шууд элсэн суралцдаг. 3,7-оос дээш голчтой бол 20 хувийн тэтгэлэгт хамруулдаг журамтай.
- Гадаад магистрант буюу Өвөрмонгол оюутанг элсүүлж авсан боловч хэлний асуудал бэрхшээл үүссэн. Сургуулийн хэмжээнд Монгол хэлний бэлтгэл сургалт явуулсан.
- Хөтөлбөрийн багш нарын 65% нь Англи хэл хичээлүүд орох бүрэн боломжтой.
- Англи хэл дээр сургалтын төлөвлөгөө, “Нийгмийн бодлого, төлөвлөлт” хичээлийн стандартын боловсруулсан.

Анхаарах асуудал:

- “Нийгмийн ажил” магистрын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн тэнхимээс элсэлттэй холбогдуулан баримтлах бодлого чиглэлийг тодорхой болгох
- Нийгмийн ажлын магистрын элсэлттэй уялдуулан Нийгмийн хамгааллын салбарын хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээг тогтмол хийдэг байх.

Зөвлөмж:

- Гадаад орнуудын их сургуулиудтай хамтарсан магистрын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой байна.
- Элсэлтийг шударга, ил тод зохион байгуулж буй эсэхэд дүн шинжилгээ хийдэг байх
- Элсэгчдэд зориулсан мэдээллийн хүртээмжийг сайжруулах
- Сүүлийн 5 жилийн элсэлтийн байдлаас авсан туршлага, сургамж, шаардлагатай арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн байдлыг тайландаа тусгах
- Гадаад хэлний шалгалт авсан байдал, мэргэжлийн шалгалт авсан байдал сүүлийн жилүүдэд байхгүй байна. Үүнийг сэргээх нь мэргэжилтэний мэдлэг, ур чадвар, хандлагын чанарт эерэг нөлөөлөл үзүүлнэ.

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын сургалтыг зохион байгуулах МУБИС-ийн журам
- Суралцагчийн ачаалалыг тодорхойлсон баримт
- Цахим сургалтыг зохион байгуулах журам
- Цар тахлын үеийн цахим сургалт сургалт зохион байгуулсан тайлан
- Нийгмийн ажил сургалтын хөтөлбөрийн талаар хийсэн сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрант оюутнуудын сургалтыг зохион байгуулахдаа жилийн аль ч улиралд явуулж болохоор сонголт хийлгэдэг байна. Бүтэн жилийн туршид сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.
- Судалгааны болон суралцахуйн арга барилыг хөгжүүлэхэд баримтлаж буй бодлого, журамтай.

Анхаарах асуудал:

- Сонгох хичээлийн тоо их байгаа нь магистрант оюутнуудын хувьд сонголт хийхэд бэрхшээл учрах ба огт сонгогдоогүй хичээлийг сүүлийн 5-н жилийн байдлаар хасч болох талаар үнэлгээ хийх

Зөвлөмж:

- Магистрын сургалтын хөтөлбөрт 2 багц цагтай хичээлийн эзлэх хувь өндөр байгаа нь суралцахуйн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй учир хичээлүүдийн багц цагийг 3 болгоход анхаарах

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Судалгааны болон суралцахуйн арга барилыг хөгжүүлэхэд баримтлаж буй бодлого, журам. МУБИС. 2020 он
- Өмнөх болон одоогийн сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт оруулсан харьцуулалт /2008 он, 2014он , 2016 он, 2020 он/
- Тэнхим хөгжүүлэх төлөвлөгөөний тайлан. 2018-2022 оны тайлангууд
- СУМС, Теамс-365 удирдлага мэдээллийн систем.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн арга зүйд өөрчлөлт оруулахад нөлөөлсөн олон төсөлт ажлуудад оролцсон байдал нь ололттой давуу тал болжээ.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч БАГШЛАХУЙН хүний нөөцийн Нийгмийн ажлын шинжлэх ухаанаар докторын зэрэгтэй байх байдлыг огт дурдаагүй байна.

Зөвлөмж:

- Судалгааны болон суралцахуйн арга барилыг хөгжүүлэх талаарх бодлого, зохицуулалтын талаар сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн байдлыг өөрийн үнэлгээний тайланд тусгах
- Бие даан суралцах болон идэвхтэй суралцах арга барилыг магистрант эзэмшиж байгаа байдлыг тодорхойлох
- Магистрант оюутнуудын тухайн хичээлийн хөтөлбөрт бие даан суралцах сэдэвчилсэн төлөвлөгөөг тусгах

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах үр чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистр оюутны эрдэм шинжилгээний ажлыг удирдах МУБИС-ийн дүрэм, журам

- Судалгааны ажлыг хэлэлцсэн тэнхимийн хурлын протокол. 2019, 2022

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрант болон удирдагчийн хамтын үйл ажиллагааг хангаж, судалгааны ажлыг идэвхжүүлэх боломжоор хангадаг байна. Сүүлийн 3-н жилийн байдлаар магистрантуудын төсөлт ажлуудад оролцсон байдлаар тодорхойлогдож байна.

Анхаарах асуудал:

- Магистрын судалгааны ажлыг удирдах Нийгмийн ажлын мэргэжлийн эрдмийн зэрэг, цолтой багшийн тоонд анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэх тэнхимийн судалгааны тэргүүлэх чиглэл, ололт амжилт, туршлага, үр дүн, дүгнэлтүүдээс тусгах;

2.5 Бүтээлч ажил

Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

- Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх журам. МУБИС.2015
- Хурлын зар, хурлын хөтөлбөр, хэвлэгдсэн сэтгүүл/Нийгмийн ажлын онол, практик/
- “Нийгмийн ажлын онол практик” сэтгүүлийн өгүүлэлд тавих шаардлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрантуудыг сүүлийн 5-н жилийн байдлаар шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд тогтмол амжилттай оролцуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Өөрийн сургуулийн хүрээнээс гадна зохион байгуулагдсан ЭШХ-д оролцсон байдал
- Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой эсэх
- Магистрант оюутнуудын дадлагажуулах байдал тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үр дүн, магистрантын судалгааг дэмжих чиглэлээр хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын үр дүнг тайланд тусгах
- Магистрантын бүтээлч ажлыг дэмжих урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоо бүрдүүлэхэд анхаарах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх журам гарсан хэрэгжиж байна.
- Багш бүр журмын дагуу сургалтын мэдээллийн системд хичээлийн жилийн эхэнд цахим сорилын санд даалгаварын санг бүрдүүлж оруулдаг. Тухайлбал нийт 7 багшийн 7 хичээл дээр 14 бие даалт, 11 багц сорилын сангийн 352 тест цахим санд байршсан байна.
- Суралцагчдад зориулсан хичээлийн хөтөлбөрийн дагуу нэр бүхий дөрвөн хичээлийн гарын авлагыг боловсруулж цахим санд байршуулсан байна.
- Багш нар суралцагчдын мэдлэг ур чадварыг хөгжүүлэх зорилгоор хичээлийн агуулгын дагуу е-контент подкаст бэлтгэж байршуулсан байна.
- Хамтын ажиллагаатай байгууллагатай төгсөгчдийг ажлын байранд холбон зуучлах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг.
- Сүүлийн 5 жилд 13 магистрант төгссөн бөгөөд төгсөгчдийн ажил эрхлэлт 100 хувьтай байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн магистрантурт бакалаврын хөтөлбөрөө тус сургуульд эзэмшсэн элсэгчид ихэнх нь байгаа бөгөөд нөгөө талаас ажил эрхэлдэг элсэгчид суралцдаг онцлог байна.

Анхаарах асуудал:

- Цаашид төгсөгчид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж байгаад судалгаа тогтмол хийж түүний үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад тусган ажиллах шаардлагатай. Элсэгчдийн тоо буурч байгаад дүгнэлт хийж ажиллах.

Зөвлөмж:

- Суралцагчдын мэдлэг, ур чадварыг үнэлж байгаа байдал цахим сорилын санд хэт тулгуурласан байгаа учраас цаашид үнэлгээний олон талт хэлбэрийг хослуулан ашиглах, суралцагчдын судалгааны чадавх, хандлага, соён гэгээрүүлэх ажлын үнэлгээг үнэлэх аргачлал, арга зүй боловсруулах, хөтөлбөрийн үнэлгээнд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй.

3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжин суралцах, кр цаг дүйцүүлэн тооцох журам гарсан.
- Тэнхимийн магистрантурын төгсөгч Б.Санжааг 2021 оны захиралын тушаалаар тэнхимийн туслах багшаар ажиллуулж байна. Үүнтэй холбоотой хөтөлбөрийн сургалт, судалгаа, олон нийтийн ажилд идэвхтэй оролцон ажлын тайлан бичиж хамгаалсан байна.
- МУБИС-ийн захирлын 2015 оны А/172 тоот тушаалаар төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг журамласан бөгөөд тус журмын дагуу бакалаврын дүнгийн голч 3.7 оос дээш бол магистрын сургалтын төлбөрийн 15 хувийг хөнгөлөн суралцуулах боломжтой байна. Үүнийг суралцагчийг дэмжсэн үйл ажиллагаа гэж үзэж байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийг төгсөгчийг магистр таа үргэлжлүүлэн суралцах тохиолдолд дүнгийн голчоос хамаарсан төлбөрийн хөнгөлөлт эдлэх журам гарсан хэрэгжиж байгаа нь элсэгчдийг дэмжсэн бодит дэмжлэг болж байна.
- Магистр төгсөгчөөсөө хөтөлбөрийн судалгаа, сургалтын туслахаар цалинтай гэрээ байгуулан ажиллуулж байгаа нь тэнхим, хөтөлбөрийн сургалт, судалгаа, олон нийтийн ажилд дэмжлэг болж байна.

Анхаарах асуудал:

- Кр цагийг бусад сургууль болон сургууль дотроо харилцан зөвшөөрөх дүйцүүлэх талаар анхаарч ажиллах. Хэдийгээр журам гарсан хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна. суралцагчид, төгсөгчид энэ талын мэдээллээр хангагдаагүй байна.

Зөвлөмж:

- Бусад их, дээд сургууль, судалгааны хүрээлэнтэй хамтын ажиллагааг эрчимжүүлж харилцан хичээл сонгон судлах, кр цаг дүйцүүлэх, суралцагчийн академик эрх чөлөөг хангах, сонголт хийх боломжийг өргөжүүлэх замаар сургалтын чанарт илүү ахиц гарган ажиллах боломж байна

3.3 Магистрантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны хөгжлийг дэмжих төвд суралцагчид шийдвэрлүүлэх асуудлаа ханддаг бөгөөд тэнхимд төдийлөн гомдол санал ирдэггүй байна.
- Цар тахлын үед өмнөд хөршөөс суралцаж байсан суралцагчид цахим сургалт, сургалтын мэдээллийн системтэй холбоотой зарим нэгэн асуудал тавьж байсныг тэнхимийн багш нар хариуцан тухайн үед нь шийдвэрлэж байсан.
- Нийгмийн ажлын хөтөлбөрт сүүлийн 5 жилд 7 гадаад иргэн элсэн суралцсан бөгөөд тэдгээрийн 3 нь сургалтаа бүрэн дуусгаж магистрын судалгааны ажлаа бичиж төгссөн байна.
- 2022-2023 оны хичээлийн жилд нийт 13 магистрант элссэн бөгөөд түүний 4 нь буюу 30 хувь нь гадаад элсэгчид байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ны элсэгчид байна.

- Хөтөлбөрийн суралцагчдыг нэгтгэдэг цахим хуудастай бөгөөд түүнийг тогтмол шинэ мэдээ, мэдээллээр хангах асуудлыг тэнхимийн судалгааны туслах хариуцан ажиллаж байна.
- Суралцагчдаас сэтгэл ханамжийн цахим санал асуулгыг 10 асуултын дагуу авдаг бөгөөд түүний үр дүн багш бүрт ирж тухайн багш өөрийн үнэлгээнд анализ хийж цаашдын сургалтын үйл ажиллагаанд тусган ажиллаж байна.
- Охидыг бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх төслийн хүрээнд сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр тэнхимийн 2 багш ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнаар ажилладаг магистрын суралцагчдад хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.
- Бакалавр оюутнуудын танилцах дадлагыг зохион байгуулах хүрээнд нийгмийн ажлын практикт ажиллаж буй магистрын суралцагч нартай нийгмийн үйлчилгээний байгууллагуудад хамтран зохион байгуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийгмийн ажил арга зүйн магистрын хөтөлбөрт гадаадын элсэгчид элсэн суралцах байдал сайн байна.
- Оюутны хөгжлийн төв гэсэн бие даасан нэгжтэй учир суралцагчид тэнд өөрсдийн гомдол санал хүсэлтийг уламжлан шийдвэрлүүлж байна. тэнхимийн дэргэд 3 төрлийн цахим хуудас ажилладаг тул мэдээллийг түргэн шуурхай түгээх боломжтой.
- Сургуулийн хэмжээний гадаад суралцагчдыг хариуцах багшийг тухайн хичээлийн жилд томилон ажиллуулдаг дотоод зохицуулалттай байна.

Анхаарах асуудал:

- Тэнхим хөтөлбөрийн зүгээс элсэгчдийн суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд зөвлөн туслах, дэмжих үйлчилгээг сайжруулах.

Зөвлөмж:

- Гадаад болон дотоод элсэгчид, бусад тусгай хэрэгцээт зэрэг элсэгчдийн онцлогт тохирсон үүссэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хэн хэрхэн хандах талаар мэдээлэл, гарын авлага бэлтгэж хүргэх шаардлагатай.

3.4 Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн оюутны журмын 5.11 д “Бүрэлдэхүүн сургууль нь оюутны судалгааны ажлын санхүүжилтэд зориулж тухайн сургуулийн оюутны жилийн нийт сургалтын төлбөрийн 0.1 хүртэл хувийг МУБИС-ийн санхүүгийн жилийн төсөвт тусган оюутныг дэмжих сан үүсгэж зарцуулна” гэж заасан байна.
- 2017-2022 оны хичээлийн жилд нийгмийн ажил арга зүйн тэнхимээс эрдэм шинжилгээний 5 хурлыг зохион байгуулж нийт 93 илтгэл хэлэлцүүлснээс 10 илтгэлийг магистрт суралцагчид хэлэлцүүлсэн байна. Эдгээр хуралд нийт 14 сая 950 мянга 500 төгрөгийг зарцуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр тэнхимээс зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурал тогтмолжсон байна.
- Зохион байгуулагдсан хурал бүрт магиструудын оролцоо нэмэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалтыг зөвхөн өөрийн тэнхим хөтөлбөрөөр хязгаарлахгүй бусад их, дээд сургууль, хүрээлэнгийн хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Бусадтай сайн туршлагаа хуваалцах, мэргэжлийн олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, харилцан суралцах замаар нийгмийн ажил мэргэжлийн хөгжилд хувь нэмэр оруулах.

3.5 Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУБИС-ийн суралцагчдад судалгааны тэтгэлэг олгох журмын дагуу 2022 онд 3 магистрантын оролцсон хоёр бүлэг төслийн баг тус бүр 2.000.000 төгрөгийн судалгааны тэтгэлэг авсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрантууд судалгааны төсөл бичин шалгарч санхүүжилт авдаг тогтолцоо байна.
- Ингэснээр суралцагчид танхимийн сургалтаар олж авсан мэдлэгээ практикт туршин хэрэгжүүлэх, мэдлэг, ур чадвараа улам хөгжүүлэх боломжтой байна.

Анхаарах асуудал:

- Судалгааны тэтгэлэг өгөхөөс гадна журманд заасны дагуу тэтгэмж, хөнгөлөлт олгох замаар суралцагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг болох.

Зөвлөмж:

- Нийгмийн ажлын тэнхим учраас суралцагчдын нийгэм, эдийн засгийн байдлыг дэмжсэн олон төрөлт тэтгэмж, урамшууллыг санаачлан хэрэгжүүлж тэдний сэтгэл ханамжийг улам нэмэгдүүлэх боломжтой. Мөн тэтгэлэгт хамрагдах байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- 2018-2019 оны хичээлийн жилд 3 магистрант, 2019-2020 оны хичээлийн жилд 2 магистрант, 2020-2021 оны хичээлийн жилд 3 магистрантыг, 2021-2022 оны хичээлийн жилд 4 магистрын оюутнуудыг, 2022-2023 оны хичээлийн жилд 3

магистрантыг багш нар өөрсдийн хийж буй судалгааны ажилд татан оролцуулж чадавхижуулан, хамтын бүтээл хэвлүүлсэн байна.

- 2022-2023 оны хичээлийн жилд тэнхимийн багш нар АХБ, Хүйсийн тэгш эрхийн төвийн хэрэгжүүлсэн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдод туслалцаа үзүүлэх төслийн хүрээнд ХХГХ-ийн бэлгийн мөлжлөгт өртсөн охид эмэгтэйчүүдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх төсөл, ОУХБ, МУБИС-ийн хамтарсан Хүүхдийн хөдөлмөр- Нийгмийн ажил төслийн хүрээнд “Нийгмийн ажлын их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тусгасан байдал” үнэлгээний судалгаанд судлаачаар ажилласан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар өөрсдийн хийдэг зөвлөх үйлчилгээ, судалгааны төсөлд магистрантуудыг татан оролцуулж чадавхжуулдаг, эрдмийн бүтээл хэвлүүлэхэд нь тусалдаг, хамтран хэвлүүлдэг сайн туршлага байна.

Анхаарах асуудал:

- Хамтран ажилласан судалгааны ажлын үр дүнг сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд тусгах.

Зөвлөмж:

- Суралцагчдыг судалгааны ажилд татан оролцуулах, тэдний эрдмийн бүтээлийг хэвлэн нийтлүүлэх, олон нийтэд түгээх ажлыг илүү эрчимжүүлэх

3.7 Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистр хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг үндсэн тэнхим нэгжээс бүрдүүлэхээс гадна хамтын ажиллагаатай бусад нэгж, хүрээлэнгээс нэг хүртэлх хүнийг оролцуулан томилж байна.
- Удирдагч томилсон захирлын тушаал жил бүр гарч байна.
- Сүүлийн 5 жилд нийтдээ нийгмийн ажил арга зүйн хөтөлбөрөөр 33 магистр төгссөн байна.
- Энэ нь жилд дунджаар 5 орчим магистр төгсч байгааг илтгэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд бусад тэнхим, хүрээлэн, сургуулиас гишүүд оролцуулж байгаа сайн туршлага байна.

Анхаарах асуудал:

- Магистрын ажлын удирдагчийг томилохдоо тэнхимийн нийт багш нарын оролцоо жигд бус байна.

Зөвлөмж:

- Магистрын ажлын удирдагчийг томилохдоо тэнхимийн нийт багш нарын оролцоог жигд хангах. Хамтарсан болон бусад хэлбэрээр жигд хуваарилах. Үүнтэй холбоотой багш нарыг эрдмийн зэрэг хамгаалах ажлыг эрчимжүүлэх

3.8 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын сургалтыг амжилттай дүүргэснийг гэрчлэх батламж, гэрчилгээ, дүнгийн хавсралт олгож байна. Монгол, англи хэл, уйгаржин монгол бичгээр бичигдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС нь өөрийн онцлогт тохирсон төгсөлтийн хувцас, энгэрийн тэмдэг, батламж, гэрчилгээ олгож байна.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээний ажлын зохиогчийн эрхийн асуудлыг анхаарах.

Зөвлөмж:

